



КРЕДИТ
ББСБ

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2025 оны 10 сарын 13-ны өдөр;

Хурлын байршил: Цахимаар

Хурал эхэлсэн цаг: 14:00 цаг;

Хурлын дарга: “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Хуралд оролцсон: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин, Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн албан ёсны бүртгэлийн хаяг өөрчлөх;
2. Компанийн үйл ажиллагааны чиглэлд “Факторингийн үйлчилгээ” нэмэх;
3. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах;

Хурал нээх: Хурлын дарга Г.Сүхбаатар

“Ард Кредит ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсний дагуу энэхүү хуралдаанаа цахимаар хийж байна. Хурлын ирцийг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг урьж байна.

Хурлын ирц: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

“Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 25/01 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Ард Кредит ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус Компанийн нийт гаргасан 364,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна. Үүнээс саналын эрхтэй 360,777,434 ширхэг энгийн хувьцаанаас 299,569,334 ширхэг буюу 83.03 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөр болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын ирцтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

Хурлын дэг: Хурлын дарга Г.Сүхбаатар

Сайн байцгаана уу, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар миний бие Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 2025/39 тоот тогтоолоор хурлын даргаар томилогдсон билээ.

Өнөөдрийн хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя, Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг өөрчлөх, компанийн үйл ажиллагааны чиглэлд Факторингийн үйл ажиллагааг нэмэх, энэхүү өөрчлөлтүүдтэй холбогдуулан дүрэмд нэмэлт оруулах өөрчлөлтийг танилцуулна. Дээрх 3 асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигч та бүхэн асуулт асууж, хэлэлцэх асуудалд саналаа Ард аппаар өгөх боломжтой. Санал хураалтын дүнг нэгтгээд, тогтоолоо та бүхэндээ танилцуулаад батлуулаад хурлаа хаана. Хувьцаа эзэмшигч та бүхэнд хурлын дэгтэй холбогдуулан санал байгаа эсэхийг асуухад

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын дэгт холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

1. Компанийн албан ёсны хаягийг өөрчлөх

Танилцуулга хийсэн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар:

Компанийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, ажиллах орчны багтаамж болон хүртээмжийг сайжруулах шаардлага үүсээд байгаа юм. Одоогийн байр нь компанийн үйл ажиллагааны цар хүрээг бүрэн хангахгүй, нэмэлт өрөө тасалгаа болон дэд бүтцийн хувьд хязгаарлагдмал байдалтай байгаа тул компанийн урт хугацааны хөгжил, тогтвортой байдлыг хангах зорилгоор илүү тохиромжтой байрлалд төвлөрөх нь зүйтэй гэж үзэж, энэхүү асуудлыг та бүхэндээ хэлэлцүүлж байна.

Үүнтэй уялдуулан түрээсийн зардлыг бууруулж, хөрөнгийн ашиглалтыг оновчтой болгох, мөн тогтвортой байрлал бий болгож үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс компанийн албан ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн (14240), Энхтайвны өргөн чөлөө, 17 дугаар барилга, 9 дүгээр давхар болгон өөрчлөх саналтай байна.

Шинэ байршил нь олон нийтийн түгээмэл мэддэгээр Blue Sky Tower барилга бөгөөд компанийн үйл ажиллагааг уг барилгын 9 дүгээр давхарт шилжүүлж, хаягийн өөрчлөлтийг албан ёсоор хийхээр төлөвлөж байна. Үүнтэй холбоотой асууж тодруулах зүйл, санал байвал асууж болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид компанийн албан ёсны хаягийг өөрчлөхтэй холбогдуулан санал гаргаагүй болно.

2. Компанийн үйл ажиллагааны чиглэлд “Факторингийн үйлчилгээ” нэмэх

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны нэг төрөл нь Факторингийн үйлчилгээ юм. Факторингийн үйлчилгээ нь байгууллагын богино хугацааны хөрвөх чадварын хэрэгцээг хангах, санхүүгийн урсгалыг тогтвортой болгох зорилгоор өөрийн авлагыг гуравдагч этгээдэд шилжүүлэх, харин уг этгээд нь тухайн авлагыг цуглуулж, үүсэж болох эрсдэлийг бүрэн хариуцах санхүүгийн үйлчилгээ юм.

Энэхүү үйлчилгээ нь байгууллагын санхүүгийн эрсдэлийг бууруулж, төлбөрийн урсгалыг оновчтой зохицуулах боломжийг олгодог. Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо олгодог бөгөөд байгууллагад дараах давуу талуудыг эдлэх боломжтой болдог.

1. Авлагын дүнгээс тодорхой хувиар үйлчилгээний шимтгэл тооцох боломжтой.
2. Олгосон санхүүжилтэд төлбөрийн хугацаа дуустал хүү тооцож, нэмэлт орлого олох боломжтой.
3. Авлагын менежмент, төлбөрийн хяналт зэрэг нэмэлт үйлчилгээнээс шимтгэл авах боломжтой.

Иймд факторингийн үйлчилгээг компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэх нь зүйтэй юм байна гэж үзсэн байгаа.

3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Компанийн дүрэмд албан ёсны хаяг, үйл ажиллагааны чиглэлийг хуульд заасны дагуу тусгасан байдаг бөгөөд хаягийн өөрчлөлттэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.7 дахь заалтад Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн (14240), Энхтайвны өргөн чөлөө, 17 дугаар барилга, 9 дүгээр давхар. Утас: (+976) 77003322, info@ardcredit.com, www.ardcredit.com гэж оруулах шаардлагатай.



Хоёрдугаарт, үйл ажиллагааны чиглэл нэмэхтэй холбогдуулан Компанийн дүрмийн 2.3.7 дахь заалтад Факторингийн үйлчилгээ гэж тус тус оруулах саналтай байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн дүрмийг батлахтай холбогдуулан санал гаргаагүй болно.

Хурлын дарга Г.Сүхбаатар: Хурлын танилцуулах хэсэг дууслаа. Одоо асуулт, хариултын цаг эхэлж байна.

4. Хэлэлцэх асуудалтай холбоотой, асуулт хариулт гараагүй болно.

Хурлын дэгийн дагуу санал хураалт дууссан байна. Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын даргаа урьж байна.

5. Саналын хураалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Тооллогын комисс Ө.Бямбагэрэл:

Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтыг нэгтгэн танилцуулахад бэлэн болоод байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон Ард Аппаар ирүүлсэн саналын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ нь:**

Хурлаар хэлэлцсэн Компанийн албан ёсны бүртгэлтэй хаягийг өөрчлөх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 299,569,334 ширхэг хувьцаа эзэмшигчээс 299,246,799 ширхэг буюу 99.892 хувь нь зөвшөөрсөн санал өгч дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

Хурлаар хэлэлцсэн Компанийн үйл ажиллагааны чиглэлд “Факторингийн үйл ажиллагаа” нэмэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 299,569,334 ширхэг хувьцаа эзэмшигчдээс 299,246,799 ширхэг буюу 99.892 хувийн зөвшөөрсөн саналаар тус тус дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

Хурлаар хэлэлцсэн Компанийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 299,569,334 ширхэг хувьцаа эзэмшигчдээс 299,255,616 ширхэг буюу 99.9 хувь зөвшөөрсөн санал өгч дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй. Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг тус тус батлан шийдвэрлэлээ.

Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, энэхүү хурлын хаана уу хэмээн “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар танийг урьж байна.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр:

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.6 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2025/02, 2025/03, 2025/04 тогтоолуудыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн албан ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай барилгын 9 дүгээр давхар болгон өөрчилсүгэй.
2. “Ард Кредит ББСБ” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд Факторингийн үйлчилгээг нэмсүгэй.
3. Үйл ажиллагааны чиглэл нэмэх, албан ёсны хаягийг өөрчилсөнтэй холбогдуулан Компанийн



КРЕДИТ
ББСБ

- 3.1. Компанийн дүрмийн 1.7 дахь заалтыг “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай барилгын 9 дүгээр давхар” болгон өөрчлөх;
- 3.2. Компанийн дүрмийн 3.2.7 дахь заалтад “Факторингийн үйлчилгээ” гэж нэмэлт оруулах.
4. Энэхүү шийдвэрийн 3 дахь заалтад заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
5. Энэхүү шийдвэрийн 1 дэх заалтад заасны дагуу Компанийн албан ёсны хаяг өөрчлөх, 2 дахь заалтад заасны дагуу үйл ажиллагааны чиглэл нэмэхтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.
6. Хавсралтаар батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
7. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ч.Ганзориг)-т даалгаж байна.

Өнөөдрийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал өндөрлөж, хурлыг хааж байна. Хуралдаа идэвхитэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа.
Хурал 14 цаг 25 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА:

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Г.СҮХБААТАР

Г.ЕСҮ-ҮЖИН